

ӨНӨӨГИЙН ДЭЛХИЙН ФИЛОСОФИЙН ДҮР ТӨРХ

Түлхүүр үг: философийн хандлагууд, сонгодог онтологийн гурван хэв маяг, сонгодог биш онтологи ойлголтууд, аналитик хөдөлгөөн, философийн антропологизм, психоаналитик хөдөлгөөн, феноменологи хөдөлгөөн, структуралист хандлага, постструктуралист ба постмодернист философидолт, орчин үеийн зарим гол философи баримтлал.

Оршил хэсэг

Энэ өгүүлэл дэх "орчин үеийн" гэдэг тодотголыг үндсэндээ XX зуунд үүсэж, оршиж ирсэн философи чиглэлүүдэд холбогдуулсан болно.

Ямар ч атугай XIX зуунаас хойшхи философийн янз бүрийн сургаалтай өнгөц боловч танилцаж байхад тэдгээрийн нэлээд нь өөрийгөө философид "эргэлт", түүгээр зогсохгүй "хувьсгал" хийлээ хэмээн зарлаж, харин бусад сургаалыг "үеэ өнгөрөөсөн", "мөхөж байгаа" эсвэл "шатлал тогтоодог" гэх мэтээр шүүмжилж иржээ. Гэтэл тэдгээрийн үлэмж олон нь эдүгээ бие даасан байдлаа алдсан хэдий ч, хожим гарч ирсэн олон философи чиглэл ба сургаалд онолын хүчтэй нөлөө үзүүлж, өөр нэг хэсэг нь агуулга, хэлбэрийн зарим засвар, шинэчлэлттэйгээр өнөөг хүртэл оршсоор байгаа билээ. Ийнхүү мэдлэгийн янз бүрийн төрлийн чухал чухал үр дүнг ба нийгмийн амьдралын эерэг, сөрөг томоохон үзэгдлийг ямар нэг байдлаар ухаарсан тодорхой ололт маягтай өөр өөр философи сургаал зэрэгцэж болон өрсөлдөн оршиж байна. Энэ нь өнөөгийн дэлхийн философийн нэг чухал онцлог юм.

Энэ өгүүлэлд өнөөгийн дэлхийн философийн дүр төрхийг тодорхойлж буй янз бүрийн хүчин зүйлс дотроос хоёрыг нь онцлов. Тэдгээр нь философийн хандлага олон янз буй; орчин үеийн философийн амьдралд зэрэгцэж болон өөр хоорондоо тэмцэлдэж оршдог нөлөө бүхий философи баримтлал цөөнгүй байгаа-ийм хоёр хүчин зүйл мөн.

Нэг. Орчин үеийн философи олон хандлагатай нь

Энэ өгүүлэлд "философийн хандлага" гэдэг нэр томъёоны дор судлах зүйлээрээ ялгаатай янз бүрийн философи чиглэл ба сургуульд хүртэл сэтгэлгээний ижил хэв маяг ямар нэг хэмжээгээр илэрч буйг илэрхийлсэн болно. Ийм ойлгоцын үүднээс хандвал орчин үеийн философид дараахь хэдэн хандлага хамгийн нөлөө бүхий илэрч ирлээ. Үүнд:

1. Сонгодог метафизик сэтгэлгээ
2. Аналитик хөдөлгөөн
3. Антропологизм (хүн судлалын үзэл)

4.Психоаналитик хөдөлгөөн

5.Феноменологи хөдөлгөөн

6.Структуралист хандлага

7.Постструктуралист ба постмодернист философидолт

Орчин үеийн философийн эдгээр хандлага тус бүр нь сэтгэлгээний бие биеэсээ ялгаатай тодорхой хэв маягийг төлөөлдөг боловч тэдгээрийн алинд нь ч бусдынх нь санаа ямар нэг хэмжээгээр агуулагдаж байна.

XX зуун дахь сонгодог метафизик сэтгэлгээ. Сонгодог буюу уламжлалт философийг бүхэлд нь үеэ өнгөрөөсөн метафизик сэтгэхүй мөн гэсэн шүүмжлэлийг бүр XIX зууны эхний хагаст О.Конт нухацтай өрнүүлж, улмаар түүнээс хойш сонгодог философиос зарчмын ялгаатай сонгодог биш философийн өч төчнөөн чиглэл үүссэн ажээ. Хэдий тийм боловч сонгодог философийн нөлөө бүхий чиглэлүүд XIX зууны сүүлийн хагасаас хойш ч гэсэн цөөн бишээр үүсэж, тэдгээрийн зарим нь эдүгээ ч гэсэн оршсоор байна. Энд ялангуяа марксист-ленинист философийг онцлон дурдах шаардлагатай. XVIII зууны францын материализм, Гегелийн диалектик хоёрыг холбон нэгтгэх үндсэн дээр бүрэлдсэн энэхүү диалектик материалист философийг анх үүссэн үеэс нь л олон нэрт сэтгэгч агуулга, арга зүйнх нь үүднээс шууд ба шууд биш янз бүрийн байдлаар шүүмжилж иржээ. Коммунист загварын социализмын орнуудын хувьд албан ёсны ганц үзэл суртал нь болж олон арван жил оршиж ирсэн энэ философи сүүлийн 10 гаруй жилд нийгмийн хөрс суурийн хувьд явцгүй болсон билээ. Гэхдээ тэр нь онол, практик аль алины үүднээс гарцаагүй няцаагдаж буй томъёоллуудынхаа орыг философийн түүхэн болон орчин үеийн зарим үндэслэл, санаагаар нөхөж, улмаар ертөнцийг үзэх үзлийн болон арга зүйн үндсэн агуулгаа хадгалсан шинэ хэлбэртэй болж байна. Ийм дүгнэлтийг 1990-ээд оноос хойш Орост хэвлэгдсэн янз бүрийн сурах бичгийн заримынх нь агуулгаас үүдэн илэрхийллээ.

Гэхдээ шинэчлэгдсэн марксист-ленинист философи бол XX зууны нийгмийн философийн нэг урсгал болж үүсэж, бүрэлдсэн неомарксизмын вариант биш, харин диалектик материалист философийн өнгө засал нэлээд авсан шинэ хэлбэр мөн гэж болохоор байна.

Марксист-ленинист философиос гадна ч гэсэн ертөнцийг үзэх материалист үзлийг илэрхийлсэн философи баримтлалууд эдүгээ цөөн биш

юм. Нэн түрүүнд натурализмын зарим хэлбэр, "шинжлэх ухааны материализм" гэгч ерөнхий нэрээр судлаачид хамтатган авч үздэг олон тооны материалист урсгал зэргийг энд дурдаж болох байна.¹ Гол нь байгалийн шинжлэлийн ололт, нээлтэнд дулдуйдан үүсдэг тэдгээр материалист баримтлалыг зөвтгөх үндэслэгээ болохуйц дүгнэлтийг байгалийн шинжлэлийн зарим гарамгай төлөөлөгч хийж ирсэн байна. Тухайлбал өнөө цагийн Эйнштейн гэж өргөмжлөгддөг английн физикч Стефен Хокинг 1992 онд Би-би-си-гийн 60 гаруй жилийн түүхт алдартай тогтмол нэвтрүүлэгт өгсөн ярилцлагандаа "... Миний бүтээлүүд Ертөнцийн үүсэх явцад Бурхан тэнгэрийн ааш аяг байсан гэж ярих хэрэггүйг харуулсан"² хэмээн дурдсан байдаг.

Философийн ерөнхий үзлийн хувьд материализмыг баримтлан сурталчилдаггүй ч гэсэн нийгмийн нийт амьдралыг юм уу түүний тодорхой тодорхой үзэгдлийг материалист хандлагын үүднээс тайлбарладаг янз бүрийн сургаал XX зуунд бий болж, оршиж ирсэн билээ. Энд социал-дарвинизм, геополитик, нийгмийн экологи, шинэ мальтусч үзэл, технологийн детерминизмийн янз бүрийн баримтлал зэргийг дурдаж болох юм.

Метафизик, уламжлалт онтологийн өөр нэг хэв маяг болох объектив идеализмын орчин үе дэх үндсэн төлөөлөл нь абсолют идеализм мөн. Жинхэнэ бодит чанар бол нэгдмэл, түгээмэл, зөрчилгүй, санаалаг шинжтэй бөгөөд мөн чанар, оршихуй хоёрыг багтаагч Абсолют мөн гэж энэ философи сурталчилжээ.

Марксист-ленинист философи сонгодог онтологид субъектив идеализмыг багтааж үзсэн билээ. Угтаа субъектив идеализм бол онтологийн үүднээс биш, харин танин мэдэхүйн онол, үнэлэмжийн онол, хэл шинжлэлийн философи зэргийн үүднээс үүсэж сурталчлагдаж ирсэн түүхтэй юм. Харин гагцхүү XIX-XX зууны зааг үеэс хойш психологийн шинжлэх ухааны нөлөөгөөр субъектив идеализм нийгмийг танин мэдэхүйн салбарт онтологи ач холбогдолтойгоор илрэх болжээ. Өөрөөр хэлбэл дурдан буй үеэс хойш нийгмийн амьдралын зарим чухал үзэгдлийн шалтгааныг "амьдралын төлөөх хүсэл эрмэлзэл", "эзэрхийлэх хүсэл эрмэлзэл", "инстинкт", "бэлгийн дур

¹ см. об этом напр: Д.Армстронг. Материалистическая теория сознания. Аналитическая философия. Избранные тексты. М., 1993. М.Бунге. Философия физики. М. 1975.

² Стефен Хокинг. Хар нүх ба шинэ ертөнц. УБ., 2004, 164 дэх тал

хүсэл" зэрэг психологи хүчин зүйлс мөн хэмээдэг субъектив идеалист онтологи баримтлалууд үүсэн дэлгэрч ирсэн байна.

ХҮIII зууны францын Соён гэгээрүүлэлтийн философи, ХҮIII-XIX зууны германы философи сургаалууд, түүний дотор марксист философи аваас уламжлалт философийн онтологийг нь материализм, идеализм хэмээн хоёр чиглэлд хуваасныг XX зууны марксист-ленинист философичид даган баримталж ирсэн билээ. Гэтэл угтаа уламжлалт онтологийн өөр нэг хэв маяг бүр дундад зууны үед байсан нь шашны философи сургаалууд юм. XIX зууны эцэс үеэс хойш өнөөдрийг хүртэл философи, нийгмийн сэтгэлгээнд жинтэй байр суурь эзэлдэг олон тооны шашны философи чиглэл үүсэн оршиж байна.

Ийм учраас сонгодог философийн онтологийг хоёр гэж биш, харин гурван хэв маягтай хэмээн үзэх тохиромжтой юм. Тодруулан дурдвал шашны янз бүрийн философи чиглэлүүдийн онтологийг идеализмд хамруулж ирсэн уламжлалаас татгалзаж, түүнийг бие даасан онтологи хэв маяг гэж үзэх шаардлагатай гэж үзэж байна. Миний хувьд ийм үзлийнхээ үүднээс "шашны трансцендентализм" гэдэг болзмол нэр томъёог зарим бүтээлдээ хэрэглэж ирлээ.

XX зуунд объектив идеализмын байр суурь суларч, харин шашны трансцендентализм хүчтэй хөгжих болжээ. Энэ нь шашны трансцендентализмын төлөөлөгчид өөрсдийн үзэлд байгалийн шинжлэлийн ололт, бэрхшээл аль алинаас холбогдох үндэслэгээ гаргаж авч чадаж байгаатай ихээхэн холбоотой юм. Энд тейярдизм үүссэнийг нэг жишээ болгон дурдъя.

Шинжлэх ухааны шийдвэрлэгдээгүй асуудал нь ч гэсэн шашны философи баримлалыг зөвтгөх үндэслэгээ болох талтайгийн өөр бас нэг жишээ дурдахад Стефен Хокингийн өмнө дурдсан ярилцлаганд ертөнц яагаад үүссэн юм бол гэдэг асуулт шинжлэх ухааны хүрээ, төвшинд эдүгээ хүртэл хариултгүй байгааг дурдсаны сацуу харин шашин, теологи, шашны философийн үүднээс уг асуултанд өөрийн гэсэн хариулт байж болохыг илэрхийлэхдээ "... хэрэв та хүсч байвал энэ асуултын хариулт нь Бурхан тэнгэрийн оролцоо байж болно"³ гэсэн юм.

Аналитик хөдөлгөөн. XX зууны 20-30-аад онуудад үүсэн орших болж, Өрнөдийн оюуны соёлд, орчин үеийн технологийн хөгжилд ихээхэн

³ Мөн тэнд

ээрэг нөлөө үзүүлж ирсэн олон философи чиглэл хэдийгээр зорилго, судлах зүйл, арга зүйн зарчмаараа бие биеэсээ тодорхой ялгаатай боловч сэтгэх хэв маягаараа аналитик хөдөлгөөнд багтдаг билээ. Үүнд, хийсвэр бясалгалын үр дүн болдог философи үндэслэлүүдээс зайлсхийдэг; баримт (факт), туршлагаас дүгнэлт гаргахыг чухалчилдаг; үүний үр дүнд нарийвчилсан утга бүхий нэр томъёонууд бий болгодог; логикийн хувьд ба танин мэдэхүйн хувьд чанад үндэслэгээнүүд ашигладаг; иймд авч үздэг асуудлынхаа талаар нэгдмэл шийдвэр гаргах бололцоо уламжлалт философитой зүйрлэхээргүй ихтэй байдаг зэрэг бол аналитик аливаа философи чиглэл, сургуулийн нийтлэг чанарууд юм.⁴

Аналитик философид онолын урьдчилсан нөхцөл болж өгсөн чухал баримтлал философийн түүхэнд арвин байгаа тухай судлаачид цохон дурддаг юм. Нэн түрүүнд Сократын индуктив томъёоллууд, Платоны диалоги, Аристотелийн аналитик, софистууд ба стоичуудын семантик, ойлголтууд хэрхэн бүрддэг тухай Дж. Локкийн баримтлал, Берклигийн болон Хьюмийн эмпиризм, сэтгэхүйн тухай Р.Декартын философи үзэл, Лейбницийн философи дахь харилцааны тухай логик онол, Кантын философи дахь туршлагын тухай болон шинжлэх ухааны танин мэдэхүйн объектыг хэрхэн эмхлэн байгуулах тухай таамаглал зэргийг аналитик философийн үүслийн тодорхой уг сурвалж мөний нь хувьд судлаачид авч үздэг билээ.

Гэхдээ аналитик философи бие даасан философи хөдөлгөөний хувьд гагцхүү XX зуунд холбогддог юм. Нэн түрүүнд логик атомын тухай сургаал, неопозитивизм, лингвистик философи гурав бол аналитик философийн анхны төлөөллүүд ажээ. Жишээ нь логик атомын тухай сургаалыг үндэслэгч Б.Расселийн тайлбараар хэл бол атоман баримтуудыг тусгагч дүр байдал мөн. Энд дурдаж буй "тусгал", "дүр байдал" гэх мэт илэрхийлэл бол материалист тусгалын онолын утгатай биш, харин хэлний янз бүрийн элементийн бүтэц бол бодит байдлын, баримтын холбогдох тодорхой бүтэцтэй харгалздаг гэсэн санааг илэрхийлдэг билээ.

Неопозитивизм янз бүрийн хувилбараар үүсэн орших болсноороо аналитик философийн сонгодог илэрхийлэл юм. Тэдгээрийн төлөөлөгчид философийн үндсэн зорилт бол шинжлэх ухааны хэл бүтээж, өөрчлөх

⁴ Орчин үеийн философи дахь аналитик хандлагыг ойлгоход чухал зарим бүтээл: Аналитическая философия. Избранные тексты. 1993, Л. Витгенштейн. Философские работы.

дүрмүүдийг хэлбэрчлэхүй мөн гэж үзээд, уг зорилтоо хэрэгжүүлэх үйл ажиллагааныхаа явцад орчин үеийн информатикийн логик, семиотик үндсийг бүрдүүлэхэд жинтэй хувь нэмэр оруулж иржээ.

Гэвч тэдний анализ зөвхөн зохиомол хэлэнд, нэн түрүүнд математик логикийн хэлэнд төвлөрөхийн учир дутагдлыг энэ философийн дотроос ч, гаднаас илрүүлэх болсон байна. Үүний үр дүнд позитивист чиглэлийн хүрээнд лингвистик философи үүсэн, эх хэлэнд анализ хийх болсон бол неопозитивизмыг гэтлэн давах замаар постпозитивизм бий болж, улмаар тэр нь аналитик философийн сонгодог хэлбэрүүдийг түүхийн хувьд төгсгөл болгожээ.

Гэхдээ аналитик философийн сонгодог хэлбэр төдийгүй түүний халаа болсон сонгодог биш хэлбэрүүд хэдийгээр постмодернизм зэрэг зарим философи сургаалуудын ширүүн шүүмжлэлд өртөж байгаа ч гэсэн эдгээр аль аль хэлбэр нь философи амьдралын тавцангаас зайлах нь юу л бол. Ийм дүгнэлтэндээ зарим үндэслэгээ гаргая.

XX зууны сүүлийн хагасаас хойш неопозитивист логикчлох уламжлал Г.Н.Гудмен, У.Куайн зэрэг прагматик аналитик философичдод хадгалагдаж байгаагийн зэрэгцээ аналитик философийн уламжлалт биш шинэ шинэ хувилбар үүсэн орших болсон байна. Тэдгээр хувилбар нь неопозитивизмыг үл зөвшөөрдөг экзистенциализм, феноменологи, герменевтик зэрэг философийн боловсруулсан олон ойлголтонд аналитикчид тодорхой ач холбогдол өгсний үр дүн ажээ. Иймээс сүүлийн хэдэн арван жил дэх аналитик философийн төлөөлөгчид сонгодог аналитик философид авч үздэггүй байсан олон асуудлыг, тухайлбал ухамсрын философи, түүгээр зогсохгүй түүхийн философи, шашны философи, улс төрийн философи зэргийн асуудлыг хөнддөг болсон ажээ.

Ийнхүү орчин үеийн философийн нэг гол хандлага бол энэ философид аналитик сэтгэлгээ чухал байр суурь бүхий байгаа нь юм.

Философийн антропологи́зм. XIX зуунаас хойш антропологи́зм (хүн судлалын үзэл) бол дэлхийн философийн маш чухал нэг хандлага болж ирсэн билээ. "Хүн" гэдэг ойлголтыг философийнхоо суурь категори болгож, хүнийг философидолтынхоо эхлэл ба эцсийн зорилт хэмээн үзэж, ингэхдээ хүний бүхэллэг чанарын аль нэг юм уу зарим хэдэн талыг онцолсон янз

Ч.1., М., 1994; Б.Рассел. Проблемы философии. М., 1914; Т.И.Хилл. Современные теории

бүрийн ойлголтоор түүнээ илэрхийлдэг философи чиглэл дурдан буй үеэс хойш үүсэн, улмаар нөлөө нь өсөх буурах, оршин тогтнол нь хадгалагдах, үгүй болох зэрэг янз бүрийн учрал, хувь заяа тэдгээрт үргэлжилсээр байна. Эдүгээ тэдгээр философийг хамтад нь "философийн антропологи" хэмээн нэрлэдэг билээ.

Гэхдээ философийн антропологийн ХХ зуун дахь чиглэлүүдийг учир дутагдалтай хэмээн шүүмжилдэг философи байдаг төдийгүй хүний тухай асуудлыг философиос хасах нь зүйтэй гэж үздэг философи үзэл гарч ирсэн нь баримттай зүйл мөн. Тийнхүү философийн антропологийг шүүмжилдэг ба үл зөвшөөрдөг философи сургаалуудын заримынх нь гол үндэслэгээ ёсоор философийн антропологийн төлөөлөгчид хүнийг зөвхөн биологи уг чанартайнх нь үүднээс онцлоод, хүн бол нийгмийн мөн чанартай тийм нийгэм-түүхийн амьтан мөнийг жинхэнэ ёсоор авч үздэггүй аж. Бас позитивизмын янз бүрийн хэлбэр, постпозитивизм зэргийн үүднээс философийн төв асуудал бол хүний тухай биш, харин шинжлэх ухааны асуудал мөн. Гэтэл постмодернизмын төлөөлөгчид хүний тухай асуудлыг философиос хасахыг илт уриалдаг ажээ. Тэд ингэхдээ хүний тухай асуудлыг философи, шинжлэх ухаан зэрэг мэдлэгийн аль ч салбар нэг мөр шийдвэрлэж дийлэхгүй байгаа, хүн бол орчлонгийн нэг өчүүхэн бөгөөд нэн эмзэг хэсэг мөнийг иш үндэс болгодог юм.

Янз бүрийн философи сургаалын зүгээс философийн антропологизмыг тийнхүү шүүмжилж, зарим нь бүр философийн тайзнаас түүнийг зайлуулах байр суурь баримталдаг ч гэсэн орчин үеийн дэлхийн философийн амьдрал дахь олон хандлагын нэг болох энэ хэв маягийн философидолт оршин тогтнож, хөгжих оюуны бат хөрстэй юм. Өөрөөр хэлбэл хүн гэж юу болохыг аль ч философи сургаал зориуд юм уу урсгал байдлаар аяндаа шийдвэрлэж байдаг.

Монголд сүүлийн 10 гаруй жилд хүний тухай экзистенциалист, фрейдист ба неофрейдист, шашны философи чиглэлүүдийн сургаалыг авч үзсэн судалгаа, сурталчилгааг явуулж иржээ. Цаашид философичид бид философийн антропологизмын бусад холбогдох чиглэлийн агуулга, арга зүйг судлан эзэмших нь хүний тухай философийг орчин үеийн төвшинд ойлгож авах гарцаагүй шаардлага болж байна. Тухайлбал: "хүний орших модус бол

бололцоо мөн" гэдэг нэлээд алдаршсан философи томъёоллын утгыг жинхэнэ ёсоор ойлгое гэвэл Э.Кассирер, Э.Гуссерль, М.Шелер, Г.Плеснер, А.Гелен, Д.Дэвидсон, Й.Хейзинга, Х.Ортега-и-Гассет зэрэг олон сэтгэгчийн онол, арга зүйн холбогдох үндэслэлүүдийг эзэмшсэн байх шаардлагагатай юм. Тэдгээртэй зэрэгцүүлээд эртний Дорно дахины орнуудын философи сэтгэлгээн дэх холбогдох үзэл санаануудыг судлан эзэмшиж, сурталчлах ажил бас хоцрогдож байна.

Эдүгээ үед философийн антропологийн хүрээнд дэвшин гарч ирдэг тус тус асуудал нь сэдвийн хувьд хүний танин мэдэхүй, ойлгохуй, мэдрэхүй, инстинкт зэрэг сэтгэлийн бүх гол хэлбэрийг ч, бас шинэчлэх, хадгалах, өөрчлөх, устгах, бүтээх зэрэг үйлдлийн аливаа чухал чадварыг ч хамарч байна. Энэ нь хүний тухай асуудал цаашид ч философийн олон чиглэлийн нэн чухал сэдвүүдийнх нь нэг байсаар байхад хүргэх болов уу.⁵

Психоаналитик (сэтгэл судлалын) хөдөлгөөн. З.Фрейд өөрийн боловсруулсан психоанализ (сэтгэл судлал)-аа анхандаа неврозыг эмчлэх арга болгон бий болгоод аажимдаа зүүд, буруу үйлдэл зэргийг судлахад ашигладаг болжээ. Энэ нь психоанализ яваандаа сэтгэлийн аливаа чухал үзэгдлийг судлах техник болж хувирахад хүргэсэн байна. Тэгээд психоанализ нь агуулга, арга зүйн хэрэгслийн хувьд метафизик философиос төдийгүй сонгодог психологиос ялгаа бүхий тийм шинжлэх ухааны салбар, философи баримтлал хоёрын уялдмал сургаал болжээ. Тийм учраас З.Фрейд энэ сургаалаа "метапсихологи", "ухамсаргүй сэтгэлийн психологи" гэх мэт жич нэртэй болгосон бололтой.

З.Фрейдийн онолд неофрейдистууд ба постфрейдистууд их, бага ямар нэг хэмжээгээр шүүмжлэлтэй хандсаны зэрэгцээ психик (сэтгэл) бол биеийн янз бүрийн инстинкт, ухамсарт биш дур хүслийн чадавхиар тэжээгддэг тийм эрчмийн тогтолцоо, иймд оюуны соёлын аливаа элемент бүрдэх үндэслэгээ мөн гэдэг үндэслэлийг нь бүгд судалгааныхаа баримжаа болгожээ. Тийнхүү психоаналитик судалгаа бол өрнөдийн философийн нөлөө бүхий бас нэг хөдөлгөөн юм.

⁵ Философийн антропологийн зарим гол төлөөлөгчдийн үзэлтэй танилцах, философидолтын энэ хэв маягийн өнөөгийн байр суурь ба цаашдын хандлагын талаар хувийн дүгнэлт гаргах зэрэгтээ миний ашигласан зарим эх сурвалж ба тайлбар бүтээл: Проблема человека в западной философии. Сборник переводов. М., 1988; Культурология. XX век. Словарь. СПб., 1997, соответствующие переводные труды; Феномен человека. Антология (перевод) М., 1993. М.Шелер. Человек и история. (1926)-Избранные произведения. М., 1994. К.Леви-Строс. Структурная антропология. М., 1985.

Фрейдист, неопрейдист, постфрейдист янз бүрийн сургаалыг тодорхой утгаар хүний тухай өвөрмөц философи хэмээн ойлгож болохоор байдаг. Ийм утгаар бол тэдгээр сургаалыг орчин үеийн философийн антропологи хөдөлгөөнд багтааж болмоор. Гэвч психоанализ бол зөвхөн антропологизм төдий биш юм. Учир нь, психоанализ нь философийн төвшинд бодгаль хүний юм уу хамт олны сэтгэлийн янз бүрийн давхрааг илрүүлэн тайлбарласан үр дүн төдий биш, харин нийгэм, соёлын үзэгдлүүдийн шалтгааныг ухаарах, ертөнцийг үзэх үзлийн болон зан суртахууны янз бүрийн асуудлыг авч үзэх онолын оролдлогуудын цогц юм.⁶

Феноменологи хөдөлгөөн. XX зуунд "феноменологи" гэдэг нэр томъёо германы төдийгүй дэлхийн философийн хамгийн гарамгай төлөөлөгчдийн нэг болох Э.Гуссерлийн бий болгосон философийг илэрхийлдэг нь бидэнд ойлгомжтой. Улмаар феноменологи нь экзистенциализм, неотомизм, постструктурализм ба постмодернизм зэрэг философи чиглэлд, бас социологи, гоо зүй, түүх зэргийн зарим салбар гэх мэт шинжлэх ухааны салбарт агуулга, арга зүйн хувьд хүчтэй нөлөөлсөөр өнөөг хүрчээ. Ийнхүү Э.Гуссерлийн феноменологи бол XX зууны эхний хагасын нэг философи чиглэл төдийгүй эдүгээ үеийн философи, оюуны нийт соёл дахь чухал хөдөлгөөн юм.

Энд Э.Гуссерлийн феноменологийн агуулгыг бүхэлд нь илэрхийлэх зорилго тавилгүйгээр харин түүний ямар ямар ойлголт, баримтлал нь XX зууны философид хэрхэн нөлөөлж ирснийг цухас дурдах болно.

"Феномен" гэдэг үг ерийн ухамсрын төвшинд "үзэгдэл", "гоц үзэгдэл" гэх мэт утгыг илэрхийлдэг бол Э.Гуссерльд энэ нь нэн чухал философи утгатай нэр томъёо билээ. Түүний хувьд феномен бол объектив юм, үзэгдэл биш, сэтгэл үүсгэгч ямар нэг тэмдэг биш, харин сэтгэхүйгээр бүрэлдэж, ухамсрын дотоодод сэтгэгдэгч болдог тийм зүйл мөн. Өөрөөр хэлбэл феномен бол объектоор тодорхойлогдохгүйгээр харин ухамсраар өөрөөр нь тодорхойлогдон, ухамсарт өгөгдөгч зүйл мөн. Ингэж өгөгдөх нь хэл, мэдрэмж хоёроор дамждаг гэж Э.Гуссерль үзжээ.

⁶ Психоанализ дахь философи утга учрыг илрүүлэхэд чухал зарим бүтээл: З.Фрейд. Лекции по психоанализу. М., 1989; Психоанализ и современная западная философия. М., 1990; Ж.Лакан. Инстанция буквы в бессознательном, или судьба разума после Фрейда. М., 1997; Нэмэлт: В.М.Лейбин. Фрейд. Psychoanalysis and Philosophy. N.Y., 1970

Ийнхүү феномений тухай Э.Гуссерлийн философи баримтлалд Дж.Беркли, Д.Хьюм, И.Кант нарын субъектив гносеологи үзэл, хэлний тухай Л.Фон Гумбольдтийн философи баримтлал зэргийн нөлөө анзаарагдаж байна.

Гэхдээ Э.Гуссерль субъективизмыг зөвшөөрснөөрөө л Беркли нартай арга зүйн холбоотой байдаг ч уг үзлээ эмпиризмд үндэслээгүйгээрээ тэднээс ялгардаг ажээ. Тэрээр позитивизмээс эрс зай барьсан байна. Ийм байр сууринаасаа шинжлэх ухааны авч үздэг зүйл нь бодит үзэгдэл, туршлагын элемент биш, харин эйдос (мөн чанар) байх ёстой гэж Э.Гуссерль үзжээ. Энэхүү эйдос нь "хүний" шинжгүй, цаг хугацааны шинжгүй тийм санаан ертөнц мөн.

Угтаа шинжлэх ухаан гадаад ертөнцийг, объектыг танин мэдэх зорилго тавьдгийг нь үгүйсгэх аргагүй билээ. Э.Гуссерль ч гэсэн үүнийг үгүйсгээгүй аж. Гэхдээ түүний дүгнэлтээр шинжлэх ухаан ийм тохиолдолдоо янз бүрийн мэдлэг бий болгодог ч тэдгээр нь үнэн байж тэр бүр чаддаггүй. Тэдгээрийн нэлээд нь үнэн биш "зохиомол бодол" байдаг. Гагцхүү феноменийг интуитив байдлаар "барьж авч", ухамсар луу өөр лүү нь хандсан (интенциональ) мэдлэг үнэн байж чаддаг гэж Э.Гуссерль үзсэн юм. Энэ нь "мэдлэг үнэн байхуйн шалгуур нь илт чанар мөн" гэсэн үг ажээ. Түүний тайлбараар илт чанар бол юмыг сэтгэхүйд тэмдэглэн буулгасан утга, бясалгасан утга хоёрын бүрэн тохироог мэдрэхүй мөн. Иймд үнэн бол энэ хоёр утгын тохироо юм.

Э.Гуссерлийн хувьд бясалгал бол гадаад ертөнцийг биш, харин утгуудын холбоог ухаарахуй мөн. Энэ үзэл герменевтик философийн төлөвшилд арга зүйн чухал түлхэц болсон байж чадахаар юм аа.

Мэдлэг, объект хоёрын тохироог биш, харин утгуудын тохироо ба нэгдлийг, өөрөөр хэлбэл ухамсар дотор юм өөрөө өөртэйгөө адил байхыг, ахуй тодорхой байхыг үнэн гэдэг Э.Гуссерлийн ийм үзэл нь экзистенциализмын зарим төлөөлөгчдөд хүчтэй нөлөөлсөн байна. Тухайлбал М.Хайдеггерийн үзлээр үнэн бол бодит юманд төсөөлөл тохирохуй биш; танин мэдэхүй, юм хоёрын тэнцэл биш; харин тэр нь хүний ахуйн аргад үндэслээд ахуйг нээгч жинхэнэ ахуй мөн.

Ийнхүү М.Хайдеггер үнэн бол хүнд түүний ахуйд нь нээгддэг гэснээрээ феноменологи редукцийг арга зүйн хувьд санагдуулдаг.

Феноменологи редукци бол аливаа бодгаль ухамсар дахь цэвэр ухамсрыг нээгч арга мөн. Э.Гуссерлийн ярьдаг цэвэр ухамсар бол юмсаас цэвэрлэсэн ухамсар биш, харин юмтай утгаараа нэгдсэнээ илрүүлдэг ухамсар юм. Ийнхүү цэвэр ухамсар бол бодит ертөнцийн юмсыг үгүйсгэдэг биш, гэхдээ тэдгээрээр объектив байдлаар тодорхойлогддог биш тийм ухамсар, өөрөөр хэлбэл өөртөө тулгаж буй ямар нэг хэвшмэл номлол, бүдүүвчээс өөрийгөө цэвэрлэдэг ухамсар мөн.

Танин мэдэхүйд ухамсар, гадаад ертөнцийн юмс хоёр бие биедээ үл уусдаг тухай, өөрөөр хэлбэл ухамсар бол юм руу биш, харин өөр лүүгээ чиглэдэг (интенциональ) тухай, иймд утгуудын холбоо бол дедуктив ба индуктив логик шинжтэй биш, харин догдлон мэдрэхүйн үр дүн мөн тухай үзэл нь антисциентизмийн янз бүрийн хэлбэр үүсэж, хөгжихөд төдийгүй сциентизмийн зарим хэлбэрийн болон лингвистик философийн төлөөлөгчид утга гэж юу вэ гэдгийг тайлбарлахад хүчтэй нөлөөлсөн байна. Жишээ нь неопозитизмын зарим төлөөлөгч утга бол субъектээс тэмдэг дээр хийдэг үйлдэл мөн гэдэг баримтлал боловсруулсан нь феноменологи дахь "интенциональ чанар", "эпохе" гэдэг ойлголтын арга зүйн утгыг санагдуулж байна. Э.Гуссерлийн философид эртний грек хэлний "тогтоон барих" гэсэн утгатай "эпохе" гэдэг үгийг хэрэглэхдээ феноменологи редукцийн дагуухь философи үйлдлийг нэрлэсэн юм. Үүнд, эпохег хэрэгжүүлсэн судлаач хүн шинжлэх ухааны ба шинжлэх ухааны биш сэтгэхүйн түүхээр бий болсон үзэл, үнэлгээнүүдэд баригдахаас чөлөөлөгддөг. Иймд судлаачийн хэрэглэж буй аливаа нэр томъёо нь тогтсон хэвшмэл утгатай биш, харин тухайн хэрэглээгээр нь нөхцөлдмөл утгатай байж таарах бөгөөд аналитик философийн олон томоохон төлөөлөгч үнэхээр тэгж үзснийг өмнө дурдсан билээ.

Феноменологи хөдөлгөөн ийнхүү орчин үеийн дэлхийн философийн маш нөлөө бүхий нэг хандлага мөнийг эдгээр өгүүлсэн зүйлсээрээ үндэслээд өндөрлөө.⁷

⁷ Эдүгээ үеийн философи дахь феноменологи хөдөлгөөний байдлыг ойлгоход онцгой ач холбогдолтой зарим бүтээлийн нэр дурдахад: Э.Гуссерль. Кризис европейского человечества и философия.-Вопросы философии. 1986, №3; Его же. Кризис европейских наук и трансцендентальная феноменология (первые 12 параграфов). – Вопросы философии. 1992, №7; Его же. Идеи чистой феноменологии. М., 1994; Аналитическая философия. Избранные тексты. М., 1993; Л.Витгенштейн. Логико-философский трактат. М., 1958; Его же. Философские работы. Ч. 1,2. М., 1994; Х.-Г. Гадамер. Актуальность прекрасного М., 1991; Ж.Деррида. Позиции. Киев, 1996; Ж.Лакан. Функция и поле речи и языка в психоанализе. М.,

Структурализм. Структурализм өргөн утгаараа нийгмийн шинжлэх ухааны болон хүмүүнлэгийн ухааны янз бүрийн салбарт хэрэглэгдэж, ингэхдээ тодорхой объектын тухайн харьцаанд онцолсон гол гол элемент, тэдгээрийн тогтвортой холбооны цогцыг, тэрхүү объектынхоо байгууламжийг илрүүлэх зорилт тавьдаг ерөнхий аргын нэр юм. Харин явцуу утгаар структурализм бол XX зууны 50-60-аад онуудад гол нь нийгмийн ба хүмүүнлэгийн мэдлэгт хэрэглэгдэж бий болсон философи онол, арга зүй мөн. Энэ өгүүлэлд сүүлийн утгыг нь хэрэглэж байна.

Философийн структурализмын үүднээс хандвал нийгмийн тодорхой үзэгдлийн бүтцийн тухай мэдлэг бол тэр үзэгдлийн тодорхой элементүүдийн цогцын тухай төдий биш, харин хамгийн гол нь уг үзэгдлийн элементүүдийг нь байр шилжүүлэх замаар хоёр дахь ба гурав дахь гэх мэт үзэгдлийг гаргаж авахад чухал тийм дүрмүүдийн тогтолцооны тухай мэдлэг мөн. Энэ философийг үндэслэгч К.Леви-Строссын үзлээр нийгмийн үзэгдэл бүхний бүтэц бол хүний үйлдлийн нэгэн төрөл тэмдэглэгээ, хэл мөн. Жишээ нь, эртний нийгмүүд дэх гэрлэх ёс журам, төрөл төрөгсдийн нэр дуудлага, аливаа баг өмсгөл, шидэт домог зэрэг бол тус бүртээ нэгэн төрөл хэл мөн. Иймд бүтэц бол үзэгдлийнхээ гадна биш, харин гүнд нь байж, судлаачийн ухамсартай төдийгүй ухамсарт биш үйл ажиллагаагаар илэрч байдаг. Тийнхүү бүтцийн тухай мэдлэг об'ектив байх бололцоо нь ухамсарт мэдлэгийнхээс, тухайлбал түүхийн тухай мэдлэгийнхээс илүү байдаг.

К.Леви-Строссын боловсруулсан сонгодог структуралист судалгааны дүрмүүдэд Ж.Лакан, М.Фуко зэрэг францын философичид зарим чухал нэмэлт хийж иржээ.

XX зууны 70-аад оны эхэн үеэс хойш философийн структурализмын зарим төлөөлөгч онолын хувьд өөрийн шүүмжлэлт байр сууринд шилжиж, улмаар постструктурализм үүсчээ. Арга зүйн онцлогийнх нь үүднээс хэлэхэд структурализм бол тэмдгийн тогтолцоонд тэмдэглэгч нь тэмдэглэгдэгчээрээ тодорхойлогддог гэсэн ахул постструктурализм нь энэ хоёрын харьцааг структурализмын эсрэг байрнаас, тэмдэглэгдэгч нь тэмдэглэгчээрээ тодорхойлогддог хэмээн тайлбарласан юм.

1995; Ж.-П.Сартр. Основная идея феноменологии Гуссерля: Интенциональность.-Проблемы онтологии в современной буржуазной философии. Рига, 1988; М.Хайдеггер. Феноменологическая и трансцендентальная философия ценности. Киев, 1996

Гэхдээ сонгодог структурализм арга зүйн хувьд зарим философи чиглэлд нөлөөлсөөр ирсэн байна. Тухайлбал феноменологийн талынхан структурализмтай сөргөөцөлдөх явцдаа шинжлэх ухаан дахь үнэний тухай өмнө дурдсан семантик үзлээ боловсруулсан гэж зарим философич тайлбарладаг юм⁸. Мөн Франкфуртын сургуулийн төлөөлөгчид оюун ухааны бүтэц ба засаглалын бүтцийг судалсан нь структурализмын нөлөө ажээ⁹.

Постструктуралист ба постмодернист философидолт. К.Леви-Строссын боловсруулсан структуралист онолыг францын зарим философич шүүмжлэн засварлах замаар XX зууны 70-аад онуудад постструктурализмд, улмаар 80-аад онуудад постмодернизмд шилжжээ.

Постмодернизмын үүднээс философи бол ертөнцийг загварчлан тайлбарласан үр дүн биш, харин уран сайхнаар философидсон эссе, өөрөөр хэлбэл философидолт байх ёстой.

Постмодернистууд ертөнцийг үзэх үзлийн аливаа хэв маягийг, хүнийг төв асуудлаа болгодог философийг, шинжлэх ухааны ганц үнэн философи бүтээх санаархал тавьдаг позитивизмын янз бүрийн хэлбэрийг үл зөвшөөрдөг үзлээ “шатлалын биш” буюу “нониерархи” зарчим хэмээн нэрлэдэг байна. Угтаа энэ зарчмын үр хөврөл постструктурализмд анх бүрэлдэж, түүний үүднээс энэ философидолтонд томъёологдсон олон үндэслэлийг постмодернизмын төлөөлөгчид үргэлжлүүлэн ашиглажээ. Тухайлбал уламжлалт философи дахь тоталитарчлах буюу бүхнийг атгагч, синтезлэгч зарчимд хэсэглэлийн зарчмыг (фрагментаризмыг) сэргүүлсэн; зохиогч хүн энэхүү зохиогч үйлийнхээ дэг жаяг, дүрэм горим, нэр хүндийн үүднээс уншигчдыг бөөцийлж, эрхшээлдээ оруулдгийн зэрэгцээ аливаа уншигч зохиолыг өөр өөрийнхөөрөө ойлгож, тайлбарладаг гэж үздэг үзлээ “зохиогч үхсэн” гэдэг томъёоллоор илэрхийлдэг; “дотоод ертөнц” хэмээн бодлогшрогч сэтгэлгээ ба догдлон мэдрэхүйн төв болдог субъектийн тухай ярих шаардлагагүй гэж үзэн, түүнээ “субъект үхсэн” гэдэг томъёоллоор илэрхийлдэг зэрэг постструктуралист үндэслэлүүд постмодернизмд орж ирсэн байна.

⁸ Энэ тухай өгүүлсэн нэг зохиол дурдъя. Структурализм: “за” и “против”. М., 1975.

⁹ Философийн структурализмын агуулга, арга зүйн онцлогийг болон бусад философид түүний үзүүлдэг нөлөөг харуулахад эх сурвалж болох зарим гол бүтээл: К.Леви-Стросс. Структурная антропология. М., 1983; Р.Барт. Мифологии. М., 1996; Ж.Лакан. Функция и поле речи и языка в психоанализе. М., 1995; М.Фуко. Слова и вещи. Археология гуманитарных наук. СПб., 1994; Его же. Археология знания. Киев, М., 1996.

Нониерархи зарчмын үүднээс хандвал постмодернист текст дэх үгс ганц биш, харин олон утга ба хэлбэр бүхий байх бололцоотой бөгөөд иймд текстийг ашиглагч нь түүнийг өөрийнхөөрөө ойлгон тайлбарлах биш, харин тэр текстийг үйлдвэрлэсэн тохируулга, зохиогчийн нь чиг баримжаа дагуу тайлбарлах ёстой.

Миний хувьд 2002 оны эхээр постмодернизмын агуулга, арга зүйг авч үзсэн "Структурализм ба эдүгээ үеийн түрүү философидолт (постструктурализм ба постмодернизм) гэсэн гарчим бүхий ном хэвлүүлсэн билээ. Тэнд постмодернизмыг эдүгээ үеийн философидолтын "түрүү" гэж тодотгохдоо түүнийг "хамгийн шилдэг" гэсэн биш, харин "тэргүүн эгнээнд байдаг" гэсэн утгаар өгүүлсэн билээ. Угтаа энэ философидолт аваас метафизик ба аналитик янз бүрийн философийн хэт хийсвэрлэсэн шинж, асуудлыг бүрэн шийдвэрлэх гэсэн оролдлого, арга зүйн дэг журам тогтоох санаархал зэргийг үл зөвшөөрсөн зүйтэй байр суурь бүхий байдаг. Энэ философийн гол төлөөлөгчдийн нэг Ж.-Ф. Лиотар бичихдээ: "...агаарын харилцаа, телевизийн харилцаа тогтсон эринд элдэв төрлийн зүйлс бие биетэйгээ хаа сайгүй тулгардаг болтлоо ойртож, өөр өөр хугацааны юм ижил хугацааных болох байдал шинэ жам ёс боллоо. Янз бүрийн баримтлал ба үзлийн давхцал, харилцан нэвтрэлцлийн ерөнхий нөхцөл бол бодитой байгаагаасаа илүү юм. Эдгээр асуудлыг шийдвэрлэх гэж постмодернизм бас оролддог... Ийм нөхцлийг постмодернизм зохиож олсон нь биш бөгөөд постмодернизм ийм нөхцлийг гагцхүү ухаардаг л юм. Постмодернизм цаг үеэс нүүрээ буруулдаггүй. Тэр нь цаг үеийг судалдаг" (Жан-Франсуа Лиотар. Состояние постмодерна. СПб., 1998, с.15-16) гэсэн юм.

Постмодернизмыг шүүмжилж, түүнийг ирээдүйгүй хэмээн оношлогч нар хүртэл постмодернизм үүссэн олон шалтгааныг тоочиж, түүний уналт гарцаагүй хэмээн тайлбарлахдаа зарим үндэслэл гаргаж ирдэг нь дашрамдаа постмодернизм бол орчин үеийн нийгмийн нөхцлийн ба оюуны дүр төрхийн бүтээгдэхүүн мөнийг гэрчилж байна. Гэвч постмодернизмын үүссэн шалтгааны тухай янз бүрийн тайлбар нь энэ философидолтыг агуулга, арга зүйн хувьд зөвхөн зөвтгөх ч, эсвэл ирээдүйгүй хэмээн зарлах ч хангалттай үндэслэл болохооргүй юм.

Постмодернист философидолтын өнөөгийн байдал, ирээдүйн тавиланд пессимист байрнаас хандах хандлагыг өрнөдийн нөлөө бүхий

зарим философич шууд илэрхийлж байгаа билээ. Тухайлбал 1998 онд болсон Дэлхийн философичдын XX их хуралд америкийн философич Д.Денетт тавьсан илтгэлдээ шинжлэх ухааны талаархи постмодернист шүүмжлэлт сэтгэлгээ нь нийгмийг хордуулах, улмаар орон нутгийн дарангуйллын засаглал тогтооход хүргэж болох тухай өгүүлжээ.¹⁰ Бас Финлянд-америкийн философич, нэрт логикч Я.Хинтиikka тэнд тавьсан илтгэлдээ философийн дискурсын (уялдмал хэллэгийн) бүтцийг тодорхойлогч ойлголт бол постмодернизмын дэвшүүлдэг деконструкци биш, харин реконструкци байх ёстой гэсэн байна. Я.Хинтикийн хувьд реконструкци бол постмодернистуудын эвдэгч, хувьсгагч үйл бүхий деконструкцид эсрэг, өөрөөр хэлбэл философийн тогтсон үзлийг хамгаалах ёстой гэдэг ойлголт юм¹¹.

Сүүлийн жилүүдэд Орост постмодернизм философид нь төдийгүй оюуны нийт амьдралд нь гүн нэвтэрч байгаагийн зэрэгцээ энэ философидолтыг эрс эсэргүүцсэн уриа лоозон, онолын бүтээл цөөнгүй гарч байна¹².

Угтаа постмодернизмд цөөнгүй учир дутагдал байдгийг үгүйсгэх аргагүй бөгөөд энэ тухай би өмнө дурдсан өөрийн номонд дурдсан билээ.¹³

Постмодернистууд сонгодог ба сонгодог биш философийн янз бүрийн чиглэлийн чухал чухал эерэг үр дүн ба эвристик үндэслэлүүдийг нониерархи зарчмынхаа үүднээс үл тоомсорлодог боловч зөвхөн өөрийгөө орчин үеийн гав ганц ухаарал гэж өргөмжилсөн нь иерархизмын нэг илрэл юм.

Гэхдээ энэ бол зарим философичийн оношилж, мөрөөддөгчлөн постмодернизм орчин үеийн оюуны амьдралын талбараас, түүний дотор философийн тайзнаас ангижирна гэсэн дүгнэлтэнд хүргэхээргүй юм. Нийгмийн амьдралын янз бүрийн хүрээнд илэрч буй тоталитаризмыг эвдэх, философийн төдийгүй мэдлэгийн аливаа төрлийн хүрээнд, аль нэг сургаал дангаар ноёрхохыг үл зөвшөөрөх зэрэг бол постмодернизм үүсэж, орших нэн чухал нөхцөл мөн. Энэ философидолт аваас сонгодог биш философийн нөлөө бүхий олон төлөөлөгчийн философи сургаалыг цулгүй үгүйсгэсэн биш,

¹⁰ См. об этом: Вопросы философии, 1999, № 5, с.62

¹¹ См. об этом там же, с.51

¹² См. об этом напр.: Д.И.Дубровский. Постмодернистская мода.-Вопросы философии. 2001, №8; А.В.Бузгалин. Постмодернизм устарел...-Вопросы философии. 2004, №2

¹³ Жишээ нь: Ц.Гомбосүрэн. Структурализм ба эдүгээ үеийн түрүү философидолт (постструктурализм ба постмодернизм). УБ., 2002, 119-124 дэх талд буй холбогдох үндэслэлүүдээс үүнийг үзнэ үү.

харин тэдгээрийг гүнзгий судлан эзэмшиж байж, тэдгээр тус бүрийн олон учир дутагдлыг илрүүлсэнд түүний амьдрах чадварынх нь бас нэг шалтгаан юм¹⁴.

х х х

Дэлхийн философийн эдүгээ үе дэх гол гол хандлагад товч үнэлгээ өгөх гэсэн оролдлогынхоо төгсгөлд хэлэхэд тэдгээрийн аль нь ч гэсэн танин мэдэхүй, үнэлэмж, үйлдлийн түүхэн тодорхой нөхцөлд эерэг ач холбогдолтой байж чадаж, үүнийхээ хүчээр бие дааж юм уу бусад сургаалд нөлөөлж буй ач холбогдлоороо оршин тогтнолоо хадгалж байна.

Хоёр. Орчин үеийн философийн гол гол онцлог баримтлал

Орчин үеийн философийн аль нэг юм уу зарим хэдэн чиглэл, урсгалд бусдаас нь тэдгээрийг агуулга, арга зүйн хувьд ялгаж өгдөг өвөрмөц чухал чухал баримтлал, зарчим байдаг билээ. Тэдгээрээс гол төлөөлөл болгож заримыг нь доор дурдах болно.

Онтологи дахь эргэлт. Ертөнцийг үзэх үзлийн тодорхой тодорхой хэв маяг болж байдаг сонгодог онтологи сургаалууд ХХ зуунд ч байгааг өмнө авч үзсэн билээ. Үүний зэрэгцээ үнэлэмж, танин мэдэхүй, хэл яриа, тэмдэглээ, практик үйлдэл зэрэг хүний субъектив янз бүрийн чадварын аль нэгийг онцлон илэрхийлсэн онтологи ойлголтыг ХХ зууны сонгодог биш янз бүрийн философи чиглэл бий болгосон юм. Тухайлбал: "хүсэл эрмэлзлэл", "амьдрал", "экзистенци" "үнэлгээ", "логик атом", "логик баримт", "феномен", "хэлний тоглоом", "ойлгохуй", "утгат чанар" гэх мэт сонгодог биш онтологи ойлголтуудыг тэдгээр философи боловсруулжээ.

Орчин үе дэх танин мэдэхүйн онолын онцлог. Сонгодог философийн аливаа чиглэлийн нэн чухал нэг бүрэлдэхүүн нь танин мэдэхүйн онол байдаг бол сонгодог биш философийн олон чиглэл өөрийгөө танин мэдэхүй биш, харин үнэлэмж мөн гэж үзээд үнэлэмжийн онол боловсруулдаг болсон билээ. Сонгодог биш философи дахь танин мэдэхүйн онолыг зөвшөөрөн боловсруулдаг чиглэлүүд нь ч гэсэн сонгодог философийнхоос

¹⁴ Постструктурализм, постмодернизмын эх сурвалж зарим гол бүтээлээс дурдахад: Жак Деррида. Позиции. Киев, 1996; Его же. Шпоры: стили Ницше.- Философские науки. 1991, №2; О грамматологии. М., 2000; H.Dreyfus, P.Rabinov, Michel Foucault: Beyond Structuralism and Hermeneutic. Chicago, 1982; Жак Лакан. Инстанция буквы в бессознательном, или судьба разума после Фрейда. М., 1997; Ролан Барт. Избранные работы. Семиотика. Поэтика. М., 1989; Ж.Делёз, Ф.Гваттари. Капитализм и шизофрения: Анти-Эдип. М., 1990; Ж.Делёз, Ф.Гваттари. Что такое философия? М., 1998; Жан-Франсуа Лиотар. Состояние постмодерна. СПб., 1998.

арга зүйн хувьд өөр байр сууринаас тийм үйл ажиллагаа явуулсан байна. Үүнд, сонгодог танин мэдэхүйн онол нь "объект-субъект" гэсэн хоёр эсрэг категорийн тойронд асуудлаа авч үздэг бол сонгодог биш танин мэдэхүйн онолууд нь тэмдгийн янз бүрийн хэв маягийг, зарим онол нь эх хэлийг шинжлэхийг судалгааныхаа объект болгож, мэдлэг бол субъектээс тэмдгэн дээр, тухайлбал үгэн дээр хийдэг нэрлэх, тэмдэглэх, утга илэрхийлэх зэрэг үйлдлийн үр дүн мөн гэж үзэж байна.

Арга зүйн сургаалын олон янз. Уламжлалт сонгодог философи голлож шинжлэх ухааны танин мэдэхүйд чухалчлагдах аргууд ба арга зүй боловсруулж иржээ. Харин уламжлалт биш философийн янз бүрийн чиглэл судлагдауныхаа онцлогт зохицсон арга боловсруулдаг болжээ. Тэгээд тэдгээр аргын зарим нь бусад философи сургаальд төдийгүй философи биш мэдлэгийн янз бүрийн төрөлд өргөн ашиглагдах болсон байна.

Гэвч философийн зарим чиглэлийн боловсруулсан арга ба арга зүйн зарчим тийнхүү өргөн хэрэглэгдэх байдлыг хэтрүүлэн үнэлэхээс зайлсхийх хэрэгтэй гэсэн арга зүйн сургааль бас гарч ирсэн билээ. Тухайлбал П.Фейерабендийн анархист арга зүй, цаашилбал постмодернист деконструкци гарч ирснээр байгаль, нийгэм, хүний сэтгэхүйд бүгдэд нь үйлчилдэг түгээмэл арга байтугай мэдлэгийн аль нэг салбарт зайлшгүй байдлаар ямагт хэрэглэгддэг арга угтаа байдаггүй гэж үздэг боллоо. Тодруулсхийн дурдвал аль ч философийн ямар ч нягтлан боловсруулсан арга байлаа гэхэд тэр нь танин мэдэхүй, үнэлэмж, практик үйлдлийн зөвхөн холбогдох нөхцөлд л үр ашигтай байдаг ажээ.

Үнэлэмж. Философи бол танин мэдэхүйн үр дүнг агуулдаг боловч тэр нь эцсийн эцэст үнэлгээ, утгыг нээхүй, ойлгохуй мөн гэдэг үзэл XIX зууны сүүлийн хагасаас хойш бие даасан олон философи чиглэл үүсэхэд хүргэж ирлээ. Нэн түрүүнд амьдралын философи, герменевтик, аналитик философийн зарим урсгал, постмодернист философидолт зэргийг энд дурдаж болох юм.

Сциентизм. Шинжлэх ухаан бол баттай үнэн, объектив мэдлэгийн юугаар ч орлогдошгүй ганц төрөл мөн гэдэг үзэл неопозитивизмд болон постпозитивизмын зарим төлөөлөгчийн үзэлд нэн тод илэрдэг билээ. Ингэхдээ тэд байгалийн шинжлэл, техникийн ухаануудын ололт ба арга хэрэгслийг ингэж дээдэлдэг юм.

Сциентизм бол орчин үеийн төрийн удирдлага, шинжлэх ухаан-техникийн үйл ажиллагааны салбар дахь технократ хандлагыг онолын үүднээс звтгөж байдаг.

Антисциентизм. Философид сциентизмийн зэрэгцээ антисциентизм хүчтэй нөлөө бүхий оршиж ирсэн билээ. Сонгодог биш философийн олон төлөөлөгч шинжлэх ухаан бол хүн ба нийгмийн суурь асуудлуудыг шийдвэрлэх, хүний дотоод ертөнцийг нээх чадваргүй гэж үзэж байлаа. Гэхдээ тэд байгалийн шинжлэлийн зохих ач холбогдлыг ор тас үгүйсгээгүй юм. Харин байгалийн ухааны ямар ч гарамгай нээлт сайндаа магадлалт шинжтэй байдаг гэж тэд үздэг билээ. Жишээ нь Ф.Ницше шинжлэх ухааныг урлагийн нэгэн төрөл гэж бичсэн байдаг нь уран сайхан үг төдий биш, агуулгад холбогдуулсан үнэлэмж байдаг юм.

Мөн постмодернистууд антисциентизмын аядуу хэлбэрийг сурталчилж байна. Тухайлбал энэ нь Ж.-Ф.Лиотарын "мэдлэгийн сортууд", "орчин үеийн мэдлэгийн уг сурвалж", "шинжлэх ухааныг ёсчлохуй" гэх мэт ойлголтоор илэрч байна.

Антисциентизмын аливаа хувилбарын нэг нийтлэг байр суурь бол тэдгээрийн аль нь ч гэсэн шинжлэх ухаан хүн төрөлхтөнд ашигтайгаасаа хортой нь илүү гэж үздэг байна.

Иррационализм. Антисциентизмын гносеологи үндэс нь иррационализм юм. XIX зууны 20-30-иод онуудаас Өрнөдийн олон сэтгэгчийн философи үзлийн чухал шинж болж анх үүссэн иррационализм хойш хойшдын философи сэтгэлгээнд хүчтэй нөлөөлж ирсээр эдүгээ үеийн философийн олонхи чиглэлийн гносеологи ба үнэлэмжийн байр суурийг тодорхойлж байна.

Ухамсаргүй сэтгэл (Unconsciousness). Ухамсараар илрээгүй тийм сэтгэлийн төлөв, үйл явц, үйлдлийн цогц бол бодгаль ба бүлэг хүн, нийт ард түмний хүртэл үйлдлийг, улмаар нийгэм, соёлын тодорхой хэв маягийг нөхцөлдүүлэгч гол хүчин зүйл мөн гэдэг үзэл философийн структурализмд, психоаналитик янз бүрийн сургууль зэргийн онолд сурталчлагдаж иржээ.

Интерсубъективизм. Орчин үеийн танин мэдэхүйн онол нь мэдлэгийн бүтцийг сонгодог гносеологиос өөрөөр авч үздэг болсонтой шууд холбоо бүхий нэг ойлголт бол "интерсубъектив чанар" гэдэг ойлголт юм. Психоаналитик онол, феноменологи, аналитик философийн янз бүрийн

чиглэл зэрэгт эл категориог ашиглахад илэрдэг нийтлэг санаа нь бодгаль ухамсар ондоо хүний туршлага болж, улмаар түүнээс түгээмэл шинжтэй туршлагад шилжиж болох тухай үзэл юм. Харин тийм шилжилтүүдийн механизмыг өөр өөр философи чиглэлд ялгаатай тайлбарладаг аж.

Синергетикийн нөлөө. XX зууны 70-аад онуудын эхэн үеэс үүсэж, улмаар орчин үеийн янз бүрийн шинжлэх ухааны, нэн түрүүнд байгалийн шинжлэх ухаануудын уулзвар дахь чиглэл болон амжилттай хөгжиж байгаа синергетикийн шинжлэх ухаан нь ертөнцийг үзэх сонгодог философийн янз бүрийн үзлийг шинжлэх ухааны үүднээс үндсээр нь өөрчлөхийг шаарддаг болжээ. Тухайлбал: синергетикийн үүднээс хандвал аливаа нийлмэл тогтолцоонд хөгжих зам тулгаж болдоггүй. Иймд тухайн тогтолцоо яаж хөгжих зохистой хандлага бүхий байгааг нь илрүүлж, түүнд нь дөхөм үзүүлэх удирдлагын үйл явц хэрэгждэг байх ёстой.

Синергетикийн үүднээс нийлмэл тогтолцооны дэг журам нь шалтгаацлаар биш, харин эмх замхгүй үйл явцаар, өөрөөр хэлбэл нийлмэл тогтолцоо өөрийгөө зохион байгуулсан үр дүнгээр тодорхойлогддог. Энэ нь нийлмэл систем бол термодинамик тэнцвэрийн янз бүрийн төлөвийн хүрээнд биш, харин тэр хүрээнээс гадна, өөрөө зохион байгуулагдсан үзэгдэл болж үүсдэг гэж синергетикт үздэгтэй нягт уялддаг байна.

Нэн түрүүнд байгалийн шинжлэлийн шинэхэн ололтуудын үр шимийг хүртэн бий болсон синергетик бол кибернетикийг халж үүссэн системийн ерөнхий онолын залуу халаа шинжлэх ухаан мөний хувьд философийн салбарт ийнхүү шинэ шинэ ойлгоц, зарчим боловсруулахыг шаардаж байгааг судлаач философичид улам бүр илрүүлэн зааж байгаа билээ. Улмаар энэ чиглэлээрхи судалгааны үр дүнгүүд нь нийгмийг танин мэдэхүй ба нийгмийн практикт хэрэглэгдэх болж байна. Синергетик бол нийгмийн амьдралын үзэгдлүүдийн ирээдүйг угтан хэлдэг зэвсэг, ерөнхий арга биш, харин нийгмийн бодит байдал руу нэвтэрч, тулгарсан асуудлыг жинхэнэ нөхцөл байдлаас нь ургуулан шийдвэрлэх талбар мөн байж чадна гэсэн санааг олон судлаач зохих үндэслэгээ гарган илэрхийлж ирлээ.¹⁵

х х х

¹⁵ Жишээ нь энэ тухай өгүүлсэн зарим бүтээлийн нэр дурдахад: Г.Хакен. Синергетика. М., 1980; И.Пригожин, И.Стенгерс. Порядок из хаоса. Новый диалог человека с природой. М., 1986; Новое в синергетике. Загадки мира неравновесных структур. М., 1996

Дэлхийн философийн өнөөгийн дүр төрхийг тодорхойлогч гол гол зарим философи сэтгэлгээний хэв маяг, философи баримтлалыг хөндөн авч үзэхэд ийм байна.

Резюме

Данная статья охватывает западную философию с периода второй половины XIX века до конца XX в.

Статья состоит из двух частей. В первой части "Многообразие тенденций современной мировой философии" автор выделяет и рассматривает следующие влиятельные тенденции мировой философии, а именно:

1. Классическое метафизическое мышление
2. Аналитическое движение
3. Антропологизм
4. Психоаналитическое движение
5. Феноменологическое движение
6. Структуралистический подход
7. Постструктуралистическое и постмодернистское философствование

В данной статье автор отбыла поставлена цель раскрыть особенности каждой из этих тенденций современной философии.

Вторая часть статьи называется "Основные специфические концепции современной философии". В ней автор отмечает, что в рамках современной философии её отдельные философские направления и школы самостоятельным образом под непосредственным влиянием других соответствующих философских учений разрабатывают свои важные теоретические положения и подходы, которые по своему содержанию отличают данное философское направление от других философских учений. При этом автор подчеркивает такие положения, подходы и концепции, как поворот в онтологии, особенности современной теории познания, множественность методологических учений, ценностный подход, сциентизм, антисциентизм, иррационализм, бессознательное (unconsciousness), интерсубъективизм, следы синергетики. Причем автор не забывает отметить, что из вышеупомянутых подходов и концепций к отдельным философским направлениям относятся только некоторые из них.